

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/67/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Гантулга
Утас: 99372297
Цахим хаяг: tseb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 7 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
О.ЭНХЖАРГАЛ ТАНАА

2026.02.25 № 120

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 7 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

- Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12,180.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8,375.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 50,997.6 мянган төгрөгийн тавилга, эд хогшил хөрөнгүүдийг холбогдох дансанд бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж, тодруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4526050090

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	378,361,518.63	283,236,236.61
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	186,598,924.34	36,201,083.14
312	Банкинд байгаа	186,598,924.34	36,201,083.14
3121	Төгрөг	186,598,924.34	36,201,083.14
31211	Төрийн сангийн харилцах	186,598,924.34	36,201,083.14
35	БАРАА МАТЕРИАЛ	191,762,594.29	247,035,153.47
351	Түүхий эд материал	7,405,809.59	5,933,019.45
35130	Эм боох материал	7,405,809.59	5,933,019.45
354	Хангамжийн материал	184,356,784.70	241,102,134.02
35410	Бичиг хэргийн материал	14,406,825.23	17,044,890.00
35420	Аж ахуйн материал	125,524,711.77	158,221,552.12
35460	Хүнсний материал	4,893,028.70	4,917,549.00
35470	Бусад хангамжийн материал	39,532,139.00	60,918,142.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,807,861,569.75	1,757,077,909.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,807,861,569.75	1,757,077,909.20
392	Биет хөрөнгийн дүн	1,512,107,204.94	1,461,548,404.35
39201	Барилга байгууламж	1,421,520,897.00	1,421,520,897.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(272,916,700.93)	(318,557,339.05)
39217	Тээврийн хэрэгсэл	44,500,000.00	44,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,912,499.83)	(23,362,499.79)
39205	Машин тоног төхөөрөмж	285,346,507.41	324,454,721.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	(92,793,722.33)	(121,017,864.59)
39207	Тавилга, эд хогшил	218,961,924.50	250,240,921.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(97,064,531.14)	(138,013,014.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,713,403.94	33,713,403.94
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,248,073.68)	(11,930,820.96)
393	Биет бус хөрөнгийн дүн	295,754,364.81	295,529,504.85
39301	Программ хангамж	674,580.00	674,580.00
39302	Хасагдуулга	(56,215.19)	(281,075.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	295,136,000.00	295,136,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,186,223,088.38	2,040,314,145.81
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	23,891,075.35
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	23,891,075.35
413	Дансны өглөг	-	23,891,075.35
4136	Ажилчдад өгөх	-	22,471,075.35
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,420,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,186,223,088.38	2,016,423,070.46
51	Засгийн газрын хувь оролцоо	2,186,223,088.38	2,016,423,070.46
511	Засгийн газрын оруулсан капитал	295,136,000.00	295,136,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,239,727,651.64	1,070,482,033.72
51210	Өмнөх үеийн үр дүн	1,239,727,651.64	1,240,282,051.64

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,029,821,470.00	2,076,641,522.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	178,369,170.00	212,089,022.90
120	Нийтлэг татварын бус орлого	178,369,170.00	199,635,122.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	43,153,600.00	93,055,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,153,600.00	93,055,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	85,623,224.00	78,223,068.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	49,592,346.00	28,357,054.90
122	Тусламжийн орлого	-	12,453,900.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	12,453,900.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,851,452,300.00	1,864,552,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,791,927,300.00	1,802,566,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,791,927,300.00	1,802,566,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,525,000.00	61,986,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,525,000.00	61,986,000.00
2	Үйл ажиллагааны зардал	1,929,262,208.35	2,246,441,540.82
21	Урсгал зардал	1,929,262,208.35	2,246,441,540.82
210	Бараа, үйлчилгээний зардал	1,912,777,441.51	2,225,911,271.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,305,307,108.87	1,598,231,655.35
210101	Үндсэн цалин	889,103,956.87	1,000,942,763.14
210102	Нэмэгдэл цалин	355,405,875.00	450,817,018.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	46,803,174.23
210104	Урамшуулал	60,797,277.00	99,668,699.62
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	170,289,140.89	196,666,600.00
210201	Тэтгэврийн даатгалын	116,238,129.26	133,633,000.00
210202	тэтгэмжийн даатгалын	13,696,285.72	15,759,200.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	6,829,363.23	7,879,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	6,705,150.99	7,879,100.00
210205	ЭМ-ийн даатгалын	26,820,211.69	31,516,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,281,033.16	44,354,730.98
210301	Гэрэл цахилгааны зардал	8,247,283.32	12,444,296.15
210302	Түлш, халаалтын зардал	21,809,727.72	20,775,716.28
210303	Цэвэр бохир усны зардал	8,224,022.12	11,134,718.55
2104	Хангамж, бараа материалын зардал	54,620,106.70	43,237,625.88
210401	Бичиг хэргийн зардал	5,576,130.00	10,059,135.23
210404	Тээвэр шатахуун	8,499,920.00	9,350,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,544,056.70	23,828,410.65
2105	Нормативт зардал	180,410,253.51	179,873,311.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,242,290.60	1,931,890.14

210502	Хоол, хүнс	179,167,962.91	177,941,420.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	2,347,200.00	3,786,300.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,347,200.00	3,786,300.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	161,522,598.38	159,761,048.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,693,620.00	11,854,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	142,828,978.38	147,907,048.55
213	Урсгал шилжүүлэг	16,484,766.84	20,530,269.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,240,800.00	17,894,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	15,240,800.00	17,894,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,243,966.84	2,636,269.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,243,966.84	2,636,269.02
3	Үйл ажиллагааны үр дүн	100,559,261.65	(169,800,017.92)
4	Үйл ажиллагааны бус үр дүн	(21,852,836.10)	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	78,706,425.55	(169,800,017.92)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,894,605,900.00	1,957,607,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,153,600.00	93,055,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	43,153,600.00	93,055,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	43,153,600.00	93,055,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,153,600.00	93,055,000.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,851,452,300.00	1,864,552,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,791,927,300.00	1,802,566,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,791,927,300.00	1,802,566,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,525,000.00	61,986,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,525,000.00	61,986,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,790,480,966.82	2,091,274,921.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,790,480,966.82	2,091,274,921.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,773,996,199.98	2,070,744,652.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,308,064,349.76	1,575,760,580.00
210101	Үндсэн цалин	838,534,488.76	978,471,687.55
210102	Нэмэгдэл	393,783,584.00	450,817,018.36
210103	Хоол унаа хөнгөлөлт	-	46,803,174.23
210104	Урамшуулал	75,746,277.00	99,668,699.86
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,531,900.00	196,666,600.00
210201	Тэтгэврийн даатгалын	113,921,700.00	133,633,000.00
210202	Тэтгэмжийн даатгалын	13,402,500.00	15,759,200.00
210203	ҮОМШӨ-ий даатгалын	6,701,300.00	7,879,100.00
210204	Ажилгүйдлийн даатгалын	6,701,300.00	7,879,100.00
210205	Эрүүл мэндийн даатгалын	26,805,100.00	31,516,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,281,033.16	44,354,730.98
210301	Гэрэл цахилгааны зардал	8,247,283.32	12,444,296.15
210302	Түлш, халаалтын зардал	21,809,727.72	20,775,716.28
210303	Цэвэр бохир усны зардал	8,224,022.12	11,134,718.55
2105	Нормативт зардал	181,950,747.06	177,965,941.20
210502	Хоол, хүнс	181,950,747.06	177,965,941.20
2106	Эд хогшил урсгал засвар	20,000,000.00	14,995,000.00
210604	Урсгал засвар	20,000,000.00	14,995,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	2,471,900.00	7,614,300.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,471,900.00	7,614,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,696,270.00	53,387,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,455,470.00	43,848,900.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	13,240,800.00	9,538,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,484,766.84	20,530,269.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,240,800.00	17,894,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	15,240,800.00	17,894,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,243,966.84	2,636,269.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,243,966.84	2,636,269.02
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	104,124,933.18	(133,667,421.12)

22	Хөрөнгийн зардал	-	16,730,420.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	16,730,420.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,280,130.00	16,730,420.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(18,280,130.00)	(16,730,420.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	85,844,803.18	(150,397,841.20)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,754,121.16	186,598,924.34
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	186,598,924.34	36,201,083.14

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	295,136,000.00	651,359,436.74	1,239,727,651.64	2,186,223,088.38
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			-	-
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	295,136,000.00	651,359,436.74	1,239,727,651.64	2,186,223,088.38
НББ-ийн бодлогын өөрчлөлт			554,400.00	554,400.00
ҮХ-ийн өсөлт, бууралт		(554,400.00)		(554,400.00)
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(169,800,017.92)	(169,800,017.92)
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	295,136,000.00	650,805,036.74	1,070,482,033.72	2,016,423,070.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,864,552,500.00	1,861,916,230.98	(2,636,269.02)	99.86
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,802,566,500.00	1,802,566,500.00	-	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,802,566,500.00	1,802,566,500.00	-	100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,986,000.00	59,349,730.98	(2,636,269.02)	95.75
132001	Орон нутгийн төсвөөс	61,986,000.00	59,349,730.98	(2,636,269.02)	95.75
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	186,598,924.34	93,055,000.00	(93,543,924.34)	49.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	93,055,000.00	93,055,000.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	186,598,924.34	-	(186,598,924.34)	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,051,151,424.34	1,954,971,230.98	(96,180,193.36)	95.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,145,822,300.00	2,105,369,072.18	(40,558,227.82)	98.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,127,928,300.00	2,087,370,072.18	(40,558,227.82)	98.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,575,810,500.00	1,575,760,580.00	(49,920.00)	100
210101	Үндсэн цалин	1,086,478,700.00	978,471,687.55	(108,007,012.45)	90.06
210102	Нэмэгдэл	398,239,800.00	450,817,018.36	52,577,218.36	113.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	46,803,174.23	46,803,174.23	-
210104	Урамшуулал	91,092,000.00	99,668,699.86	8,576,699.86	109.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	196,666,600.00	196,666,600.00	-	100
210201	Тэтгэврийн даатгал	133,633,000.00	133,633,000.00	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	15,759,200.00	15,759,200.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,879,100.00	7,879,100.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	7,879,100.00	7,879,100.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	31,516,200.00	31,516,200.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,191,600.00	44,354,730.98	(22,836,869.02)	66.01
210301	Гэрэл, цахилгаан	16,694,000.00	12,444,296.15	(4,249,703.85)	74.54
210302	Түлш, халаалт	34,295,600.00	20,775,716.28	(13,519,883.72)	60.58
210303	Цэвэр, бохир ус	16,202,000.00	11,134,718.55	(5,067,281.45)	68.72
2105	Нормативт зардал	194,971,400.00	177,965,941.20	(17,005,458.80)	91.28
210502	Хоол, хүнс	194,971,400.00	177,965,941.20	(17,005,458.80)	91.28
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,995,000.00	14,995,000.00	-	100
210604	Урсгал засвар	14,995,000.00	14,995,000.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,755,400.00	7,614,300.00	(141,100.00)	98.18
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,755,400.00	7,614,300.00	(141,100.00)	98.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,537,800.00	70,117,920.00	(524,880.00)	99.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,209,800.00	55,789,920.00	(524,880.00)	99.07
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,328,000.00	14,328,000.00	-	100

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,894,000.00	17,894,000.00	-	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,894,000.00	17,894,000.00	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,894,000.00	17,894,000.00	-	100
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,145,822,300.00	2,105,264,072.18	(40,558,227.82)	98.11
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	186,598,924.34	186,598,924.34	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	36,201,083.14	36,201,083.14	-
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1		(1.00)	
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	55	55	-	100
7	Гүйцэтгэх ажилтан	48	48	-	100
8	Үйлчлэх ажилтан	7	7	-	100

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус цэцэрлэгийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 2,316.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	2,316.6	1	2,316.6	100
Зөвлөмж	2	-	2	-	100
Нийт дүн	3	2,316.6	3	2,316.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,389.0 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудын уялдаа холбоог шалгахад 10,389.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгө дансанд бүртгэж, санхүүгийн тайлангуудын алдааг залруулав.

Мөн аудитаар нийт 4,778.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул төсөвт буцаан төвлөрүүлэх 600.0 мянган төгрөгийн акт, зөрчил таслан зогсоох 4,178.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч О.Энхжаргалын сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 3-д "Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1.Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн эрхлэгч О.Энхжаргал нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,169.2 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2.Илрүүлэлт: Тус цэцэрлэгийн нягтлан бодогч Э.Энхцэцэт Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 1,559.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай", "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн хоорондын уялдаа 10,389,000.00 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	10,389.0	-	-	1	10,389.0	1	10,389.0	-	-	-	-
Дүн	1	10,389.0	-	-	1	10,389.0	1	10,389.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч О.Энхжаргалын сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн эрхлэгч О.Энхжаргал нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619,200.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	1	2,619.2	-	-	1	2,619.2	-	-	-	-	-	-

Тус цэцэрлэгийн нягтлан бодогч Э.Энхцэцэгт Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 24-ны өдрийн Б/50 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалин 1,559,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.	1	1,559.0	-	-	1	1,559.0	-	-	-	-	-	-
Дүн	1	4,778.2	1	600.0	2	4,178.2	-	-	-	-	-	-